



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар

4164

Ховд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн газар чөлөөлөлтийн зардлын ажилд дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Элбэг гүн” ХХК-ийн хийж гүйцэтгэж буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажилд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдсэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төвийн газар чөлөөлөлтийн зардлын ажлыг нягтлан шалгаж шууд гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Туулайтулга - Жаргалант сумын Засаг даргын орлогч

Гишүүд: Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Л.Билэгдэмбэрэл - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын  
дарга

Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах  
ажиллагааны албаны мэргэжилтэн

Ж.Сүхбаатар - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн


А.Чинзориг - “Элбэг гүн” ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын  
газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Туулайтулга)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

8400 01 1-10